

Фа бясалгалд тулгарч буй гамшиг

Дафа-гийн шавь нар Багшийгаа даган амь бодийг аварч байна. Энэ бол түүхэн зайлшгүй шаардлага, түүхийн өмнөх үед та бүхний өргөсөн тангараг, орчлон ертөнц үүссэн цагаас хойш урьд өмнө хэзээч байгаагүй агуу, ариун алдар гавьяа юм. Гэхдээ энэ үйл явц хүнд хэцүү бөгөөд аюултай. Хүний орчлонд Дафа-гийн шавь нарын үзүүлж буй агуу нинжин сэтгэлийг ойлгоход хүмүүст тун хэцүү байдаг. Дафа-гийн шавь нар хэлмэгдүүллийг эсэргүүцэж, хүмүүнийг аварч байхад үүнтэй зэрэгцэн хүн төрөлхтний ард байгаа ёрын муу сүнснүүд Дафа-гийн шавь нарыг болон над руу янз бүрийн хэлбэрээр дайрч, дарамтлахад хүмүүсийг турхирч байна.

Фа бясалгалд тулгарч буй гамшиг 1999 онд Хятадад эхэлснээс хойш өнөөг хүртэл АНУ-д ч бай дэлхийн хаана ч бай дуусаагүй байна. Хүмүүсийг аврах түүхийн явцад тэдний бий болгосон үйлийн үр нь хөндөгддөг, үүнийг чөтгөрүүд ашиглан хэзээ ч хаана ч саад бэрхшээл, хор хөнөөл учруулж болно. Дафа-гийн шавь нар Багшаа даган хүмүүсийг аврахын зэрэгцээ өөрсдийгөө мөн аварч байна, өөрсдийн үйлийн үрийг арилгаж байна. Чөтгөрүүд Дафа-гийн шавь нарын хүмүүсийг аврах чармайлтыг зогсоохын тулд өөрсдийнх нь үйлийн үрийг ашиглана. Тэдгээр аврагдаж буй хүмүүс өөрсдийн түүхийн туршид үйлдсэн бүх үйлийн үр, нүглээ төлж чадахгүй, тиймээс Бурхад нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс зарим хэсгээс нь чөлөөлөхөд туслах ёстой, зарим хэсгийг нь хүмүүс өөрсдөө арилгах ёстой байдаг. Багш нь, би ч гэсэн тэдний төлөө зарим хэсгийг нь үүрэх ёстой байдаг. Тиймээс хэдий чинээ олон амь аврагдана Багш төдий чинээ ихээр тэсвэрлэх ёстой байдаг. Хэрэв Дафа-гийн шавь нар хавчлага хэлмэгдүүллийн эсрэг зогсохдоо бага зэрэг л хайхрамжгүй хандвал зовлон бэрхшээлтэй тулгарах болно.

Дафа-гийн шавь нарын үүсгэн байгуулсан хэвлэл мэдээллийн компаниудад тулгараад байгаа асуудлууд нь голчлон сурагчид өөрсдөө зөв байж чадаагүйгээс үүдэлтэй, гэхдээ хүн төрөлхтний цаана байгаа өөр орон зайнуудын хүчин зүйлс ч бас байдаг. Та нар хавчлагыг эсргүүцэхэд хөрөнгө мөнгөгүй бол хэцүү гэж бодож байна, тиймээс ХКН-ын хавчлагыг эсэргүүцэхийн тулд мөнгө цуглуулахыг хүсдэг. Хэрэв ямар нэг зүйлийг зохисгүй хийвэл Америкийн засгийн газар та нарыг ойлгоно гэж үү. Энэ бол та нарын өөрсдийн бодол. Амьд хүнээс эрхтэнг нь хүчээр авч байгаа, хэлмэгдүүлээс болж өдөр бүр хүний амь үрэгдэж байгаа энэ үед та нар тэр мөнгийг өөр зорилгоор биш харин энэ мөрдлөг хавчлага, хэлмэгдүүллийг зогсоохын төлөө хэрэглэхэд бол болно гэж бодож байна. Гэхдээ Дафа-гийн шавь нар үргэлж өөрсдийн замаар зөв явж байж л асуудлаас зайлж чадна гэдгийг мартаж болохгүй.

Бид хүмүүсийг аварч байхад нүглийн арван таван хувь нь арилаагүй байсаар байгааг би мэднэ. Энэ бол 20 гаруй жил амь бодиудыг аврах явцад үлдсэн нь юм. Энэ нь асар их гэдгийг би мэднэ. Тийм учраас асар их дарамт, ачаалал над дээр ар араасаа ирсээр байх болно. Хүнийг аврах хэцүү, энэ бол зүгээр нэг яриа биш. Тийм ч учраас хүмүүсийг аварч буй гэгээнтнүүд болох “Шэнь Юнь” урлагийн хамтлагийнхны эсрэг далд явуулга хийж байгааг бид харж байна.

Манай Дафа-гийн шавь нар ХКН-ын харгис, хүчирхэг суртал ухуулгын машины эсрэг, бүхэл бүтэн үндэстний хүчийг ашиглан бүхий л талаар дайрч байгаа ХКН-ын дэглэмийн эсрэг зогсож байна. Эх газрын Хятадаас гаднах Дафа-гийн сурагчдын тоо маш цөөн, тиймээс зарим эцэг эхчүүд хүүхдүүдээ хавчлага хэлмэгдлийн эсрэг туслалцуулах болсон. Хавчлага хэлмэгдүүллийн эсрэг тэмцлийг улам амжилттай болгохын тулд, Фэй Тиэнь урлагийн академи болон Фэй Тиэнь коллеж нь сурагчиддаа зөвхөн соёл, боловсрол олгоод зогсохгүй бас хавчлага хэлмэгдүүллийн эсрэг хүчирхийллийн бус замаар тэмцэгч, урлагийн хүн болоход нь тусалж байна. Тэд Коммунизмаас өмнөх Хятад ямар байсныг дэлхий дахинд харуулснаараа хүмүүст ХКН-ын үнэн нүүр царайг танихад тусалсан, хавчлага хэлмэгдүүллийг илчилсэн, мөн эцсийн энэ мөчид Бурхад хүмүүнийг аварч байна гэсэн мессежийг дамжуулж байна. Энэхүү тоглолтын эерэг энерги нь хүн төрөлхтөнд тулгарч буй гамшгийг арилгаж байна. Америкчууд болон дэлхий даяар энэ ашиг тусыг хүртэж байна. Өөрөөр хэлбэл Дафа-гийн гишүүн бүр хэлмэгдүүллийг эсэргүүцэж байна.

Хятадад бүх шавь нар, хүүхэд томчууд гэлтгүй бүгд зовлон зүдүүрт байна. Хүүхдүүд ч гэсэн баривчлагдан шоронд орж байна, хэлмэгдэн нас барж байна. Шэнь Юнь-ий уран бүтээлчдийн зарим нь дадлагын сурагчид байдаг, тэдний эцэг эх нь хүүхдээ боловсрол эзэмшихийн зэрэгцээ хэлмэгдүүлэлтэй тэмцэхэд оролцохыг хүсдэг. Тиймээс тэд хүүхдээ Фэй Тиэнь-д явуулдаг. Элсэлтийн үед сурагчдаас яагаад Фэй Тиэнь-д суралцах хүсэлтэй байгааг нь асуудаг. Тэд бүгд хүмүүсийг аврахад Мастерт туслах хүсэлтэй гэж хариулдаг. Тэд Шэнь Юнь-ий тоглолтод оролцож ХКН-ын хэлмэгдүүллийг илчлэх, эх газрын Хятад дахь бясалгал нэгт ахан дүүсээ аврахад туслах эрмэлзэлтэй байдаг. Хүмүүсийг аврах, хэлмэгдүүлэлтэй тэмцэхэд бидний хувьд хөгшин залуугүй бүгд үүрэг гүйцэтгэдэг, зарим хүүхдүүд маш шийдэмгий байдаг! Үнэн хэрэгтээ хэлмэгдүүлэлтийн эсрэг тэмцэх нь бидний бясалгагчдын хүрэн доторх асуудал, хэн ч бидэнд туслахгүй! Засгийн газар том компаниуд үүнд багтана. Гэсэн хэдий ч насанд хүрээгүй сурагчдыг жүжигчнээр ашиглаж байна хэмээн дэлхий нийтэд хөшигний араас өдөөн хатгалга явуулж Шэнь Юнь руу дайрахыг турхирагчид байсаар байна. Үнэн хэрэгтээ энэ нь сурагчдын дадлага хийх сургуулилтын явц юм. Бид урьд өмнө байгаагүй хэлмэгдүүлэлтэй тулгарч байгаагийн хувьд энэ хэлмэгдүүллийг эсэргүүцэхэд бүгд хувь нэмрээ

оруулах нь зүйн хэрэг юм. Хэрэв эдгээрийг Шэнь Юнь руу дайрах шалтаг болгож байвал Америк юу болж байна?

Үнэндээ, Фа бясалгалд тулгарч буй гамшиг нь өөр газар оронд байлаа гээд гарахгүй гэсэн үг биш, харин өөр өөр хэлбэрээр илрэх болно. Мөн Фа бясалгалд тулгарч буй гамшгийн үеэр эцэст нь үлдэх амь бодиуд болон устгагдах амь бодиуд сонгогдож байна, үүнд Дафа-гийн шавь байж чадах, чадахгүй хүмүүс мөн багтана.

Багш Ли Хонжи
2024 оны 6 сарын 5